# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/128 Алтай

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан хавсралтад дурдсан 1 иргэнд үнэ төлбөргүйгээр тус газрыг шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг даргын орлогч /М.Амгалан/, Улсын бүртгэлийн хэлтэс /Н.Доной/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2007 оны 98 дугаар захирамжийн хавсралтын 60 дугаарт бүртгэгдсэн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Газар өмчлөх эрх нь сэргээгдсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг заасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

02 000515

Аймгийн Засаг даргын 2014 оны 04 сарын 03-ны өдрийн
А/128 дугаар захирамжийн хавсралт

**ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ**

| д/д | Овог нэр | Ам бүлийн тоо | Хаяг | Газрын хэмжээ /м2/ | Гэр бүлийн хамтын хэрэгцээнд өмчилж авсан захирамж | | | Өмчлөх эрх шилжүүлэгчийн овог нэр | Өмчлөх эрх шилжүүлэн авагчийн овог нэр | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Огноо | Дугаар | Хавсралтанд орсон дугаар | | | |
| 1 | Доржготов Ганбаатар | 5 | Баяншанд баг 5-28 тоот | 780.6 | 2007.04.10 | 98 | 60 | Т.Цэрэндэжид<br>Г.Гаанжуур<br>Г.Даанжуур<br>Г.Мэндсайхан | Доржготов Ганбаатар | Засаг даргын захирамжаас шилжиж байгаа |

оОо

16

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 04 сарын 04 өдөр Дугаар А/129 Алтай

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь заалт зөрчигдсөн тул захирамж хүчингүй болгох тухай аймгийн Засаг даргын 2014 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/44 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

02 000545

17

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2014 оны 04 сарын 04 өдөр Дугаар А/130 Алтай

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цүлээний Бямбажавын орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 000477143 дугаартай эрхийн гэрчилгээ бүхий 302 м² газрыг Цэдэнгийн Мөнхцэцэгт шилжүүлж эзэмших газрын байршил, хэмжээг 1-2 дугаар хавсралтаар баталж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу 000477143 дугаартай эрхийн гэрчилгээг хүчингүй болгож уг нэгж талбарыг эзэмшигч иргэн Ц.Мөнхцэцэгтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Алтанзагас/-т даалгасугай.

3. Газрын тухай хууль, барилга техникийн норм, дүрмийг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны А/342 дугаар захирамжийн 2-д заагдсан хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

:/My Documents/ZAHNR 3A-4doc

02 000505

Аймгийн Засаг даргын 2014 оны 04 сарын
04-ны өдрийн А/130 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

Газар эзэмшигч иргэний эзэмших газрын
зориулалт, байршил, хэмжээ

| Д/д | Иргэний нэрс | Зориулалт | Хэмжээ /м2/ | Газрын байршил |
|---|---|---|---|---|
| 1. | Ц.Мөнхцэцэг | Орон сууц | 302 | Баянхайрхан баг Эм хангамж ХХК-ний баруун талд |

_____oOo_____

Аймгийн Засаг даргын
20 14 оны 04 дугаар сарын 04 -ны өдрийн
А/130 дугаар захирамжийн 2-р хавсралт

# ИРГЭН Цэдэн ОВОГТОЙ Мөнхцэцэг ( ДЭ66112806 ) - ИЙН ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 060728060

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Огноо: 2014-4-1

Хашааны координат:

| Дугаар | X | Y | Урт | Цэгүүд |
|---|---|---|---|---|
| 1 | 5138869.500 | 288457.350 | 15.97 | 1-2 |
| 2 | 5138856.867 | 288457.080 | 18.83 | 2-3 |
| 3 | 5138890.947 | 288469.913 | 15.97 | 3-4 |
| 4 | 5138873.879 | 288475.213 | 18.92 | 4-1 |

Талбайн хэмжээ: 302 Квадрат метр

Зураг үйлдсэн . . . . . . . . . . М.Ариунсаланг (Говь-Алтай аймгийн ГЗБГЗХБГазрын мэргэжилтэн)

(Тамга)

Хянасан . . . . . . . . . . Д.Алтанцэцэг (Говь-Алтай аймгийн ГЗБГЗарын дарга)

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 04 сарын 04 өдөр Дугаар А/131 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 60 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэр сумд хэрэгжих "Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийн ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:
- Дэлгэр сумын Засаг дарга
- Хөгжлийн бодлогын хэлтсийн хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- Мэргэжлийн хяналтын газрын барилга, техникийн хяналтын улсын байцаагч
- Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын орон сууц, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн орон нутгийн удирдлага, хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

2. "Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийн ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг танилцуулан тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

02-000570

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2011 оны 04 сарын 07 өдөр Дугаар А/132 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Концессын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Концессын гэрээгээр хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг тодорхойлж, хэлэлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Чинзориг -Аймгийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч

Нарийн бичгийн дарга: Д.Сандагдорж -Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

Гишүүд: Х.Баатарзориг -Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
Т.Гансүх -Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Д.Баттайван -Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
Ш.Эрдэнэбат -Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч /зөвшилцсөнөөр/
С.Баттөр -Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч /зөвшилцсөнөөр/
Д.Очир -Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч /зөвшилцсөнөөр/
М.Дашпунцаг -Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч /зөвшилцсөнөөр/
Д.Намсрай - Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч /зөвшилцсөнөөр/
Ч.Жаргалсайхан -Иргэний төлөөлөл

2. Концессын гэрээгээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн жилийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтод нийцүүлэн судалгаа хийх, санал боловсруулахыг ажлын хэсэг /Д.Чинзориг/-т даалгасугай.

3. Шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Х.Баатарзориг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

02000558

22

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 04 сарын 07 өдөр Дугаар А/183 Алтай

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, "Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 2, Засгийн газрын 2014 оны м/н 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2014 оны 1 дүгээр ээлжийн Цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Цэрэг татлагын товчооны дарга: П.Золжаргал –Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Орлогч дарга: М.Батсуурь – Цэргийн штабын дарга

Нарийн бичгийн дарга: Г.Баасанцог –Цэргийн штабын тоо бүртгэл, нөхөн хангалт хариуцсан офицер

Гишүүд: Г.Түмэннасан - Цагдаагийн хэлтсийн дарга

Г.Лхагважаргал -Нэгдсэн эмнэлгийн дарга

Х.Батболд -Соёл, спорт, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Г.Цэдэв -Цэргийн штабын сургалт иргэний хамгаалалт хариуцсан офицер

2. Цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагыг 2014 оны 05 сарын 01-ээс 05 сарын 05-ны өдөр багтаан явуулж, ЗХЖШ-аас өгсөн хяналтын тооны даалгаврыг биелүүлэхийг Цэрэг татлагын товчооны дарга /П.Золжаргалд/-д даалгасугай.

3. "Батлан хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар бүлгийн 12 дугаар зүйлийн 1-ийн 2, Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн өөрийн сумд цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, тогтоосон цагт хүмүүсээ иргэний үнэмлэх, холбогдох бусад бичиг баримттай нь бэлэн байлгахыг сум, багийн Засаг дарга, сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн үзлэгт сумын хүн эмнэлгийн салбарын эмчийг байлцуулах, 2013 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын товчоогоор эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлэх талаар авсан арга хэмжээг илтгэх хуудсаар танилцуулахыг сумын Засаг дарга, эмнэлгийн эрхлэгч эмч нарт үүрэг болгосугай.

5. Цэрэг татлага явуулах товчооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, эмч нарын комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, сумдын цэрэг татлагаар орох хуваарийг гуравдугаар хавсралтаар, зарцуулах хөрөнгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.

6. Ээлжит цэрэг татлагын зардалд зарцуулагдах хөрөнгө 3675000 /Гурван сая зургаан зуун далан таван мянган/ төгрөгийг цэрэг татлагын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Х.Баатарзориг/-т зөвшөөрсүгэй.

7. Цэргийн жинхэнэ албаны 2014 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлага явуулсан дүнг 2014 оны 05 сарын 20-ны дотор танилцуулж, мэдээг Батлан хамгаалах яам, ЗХЖШ-т хүргэхийг Цэрэг татлагын товчооны орлогч дарга /М.Батсуурь/, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Цэрэг татлагын товчооны дарга /П.Золжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2014 оны
04 дугаар сарын 07-ны өдрийн А/122 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

## ЦЭРЭГ ТАТЛАГЫН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

1. Цэрэг татлагын товчооны дарга: П.Золжаргал –Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

а. Цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангуулж, цэрэг татлагын ажиллагааг удирдах.

б. Товчооны гишүүдийг зохих үүргээр хангах, гишүүд үүргээ шударгаар биелүүлж байгаад хяналт тавих.

в. Товчооны гишүүдэд шаардагдах байр, хоол, томилолт, унааны зардлыг шийдвэрлэж өгөх.

г. Цэргийн албанд тэнцэгчдийг жинхэнэ алба хаалгах шийдвэр гаргаж, цэргийн анги салбарт хуваарилах ажилд хяналт тавих.

д. Цэрэг татлагын ажлын дүнг аймгийн Засаг даргад танилцуулах.

2. Орлогч дарга: Хурандаа М.Батсуурь - Цэргийн штабын дарга

а. Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах.

б. Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх.

в. Гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдыг хуваарилагдсан анги салбарт нь хүргэж өгөх.

3. Цэрэг татлагын товчооны нарийн бичгийн дарга: ахмад Г.Баасанцог – Цэргийн штабын тоо бүртгэл нөхөн хангалт хариуцсан офицер

а. Цэрэг татлагын ажлын урьдчилсан бэлтгэлийг хангах.

б. Цэрэгт татагдагчдын баримт бичгийг бүрдүүлэх, баримт бичигт бичилт хийх.

в. БХЯ, ЗХЖШ- д явуулах мэдээ тайланг гарган явуулах.

4. Гишүүн: дэд хурандаа Г.Түмэннасан -аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга

а. Цэрэг татлагын үед цэрэг татлагын байранд цагдаагийн жижүүр гарган ажиллуулах, хяналт тавих.

б. Дэлгүүр, мухлаг, үйлчилгээний газруудад согтууруулах ундааны зүйл худалдаалахыг таслан зогсоох.

в. Цэрэг гаргаж өгөх, ирэх үед хэв журам сахиулах хүч нэмэгдүүлсэн эргүүл гарган ажиллуулах.

5. Гишүүн: Лхагважаргал - Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга

а. Эмч нарын комиссыг удирдан эмч нарт зааварчилгаа өгөх, БХЯ, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 115/581/103 дугаар тушаалыг мөрдлөгө болгон ажиллах

6. Гишүүн: Х.Батболд - Соёл, спорт аялал жуулчлалын газрын даргийн үүрэг гүйцэтгэгч

а. Цэрэг татлагын байрыг бэлтгэж ажиллах нөхцөлөөр хангах

7. Гишүүн: ахмад Г.Цэдэв -Цэргийн штабын сургалт, ирэний хамгаалалт хариуцсан офицер

а. Цэрэг татлагын ажлын урьдчилсан бэлтгэлийг хангах

б. Цэрэг татлагын товчооны дотоод хэв журмыг хангах

___oOo___

Аймгийн Засаг даргын 20 14 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн А/133 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ ЭМЧ НАРЫН НЭРС

| № | Нэрс | Ямар мэргэжлийн үзлэг явуулах |
|---|---|---|
| 1 | Г.Лхагважаргал | Ерөнхий эмчээр |
| 2 | С.Оюунцэцэг | Мэдрэлийн эмчээр |
| 3 | Л.Оюундарь | Чих хамар хоолойн эмчээр |
| 4 | Г.Ичинхорлоо | Мэс заслын эмчээр |
| 5 | Ц.Оюунгэрэл | Арьс өнгөний эмчээр |
| 6 | Б.Чимэдлхам | Дотрын эмчээр |
| 7 | Ц.Цэвээн | Нүдний эмчээр |
| 8 | Б.Мижид | Сурьеэгийн эмчээр |
| 9 | н.Чулуунцэцэг | Бие бялдарын эмчээр |
| 10 | Сугармаа | ОСАЖГазар |
| 11 | Ариунаа | Эрүүл мэндийн газар |
| 12 | Х.Дэлгэр | Сувилагч лаборант |
| 13 | н.Саранцэцэг | Нүдний сувилагч |
| 14 | С.Бадамханд | Сувилагч лаборант |

___оОо___

Аймгийн Засаг даргын 20 14 оны
04 дугаар сарын 07-ны өдрийн А/122 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

СУМУУД ЦЭРЭГ ТАТЛАГЫН КОМИССООР ОРОХ ХУВААРЬ

| № | Сумдын нэрс | Хяналтын тоо | Орох он, сар, өдөр | Орох цаг |
|---|---|---|---|---|
| 1 | Тайшир | 14 | 2013.05.01 | 10.00-11.00 |
| 2 | Дарив | 12 | 2013.05.01 | 10.30-12.00 |
| 3 | Шарга | 18 | 2013.05.01 | 11.30-13.00 |
| 4 | Жаргалан | 14 | 2013.05.01 | 14.00-15.00 |
| 5 | Бигэр | 11 | 2013.05.01 | 14.30-16.00 |
| 6 | Халиун | 19 | 2013.05.01 | 15.00-17.00 |
| 7 | Хөхморьт | 17 | 2013.05.01 | 15.30-17.30 |
| 8 | Дэлгэр | 16 | 2013.05.02 | 10.00-11.00 |
| 9 | Цээл | 12 | 2013.05.02 | 10.30-12.00 |
| 10 | Эрдэнэ | 21 | 2013.05.02 | 11.30-13.00 |
| 11 | Цогт | 27 | 2013.05.02 | 14.00-15.00 |
| 12 | Тонхил | 18 | 2013.05.02 | 14.30-16.00 |
| 13 | Төгрөг | 13 | 2013.05.02 | 15.00-17.00 |
| 14 | Чандмань | 12 | 2013.05.03 | 10.00-11.00 |
| 15 | Алтай | 16 | 2013.05.03 | 10.30-12.00 |
| 16 | Бугат | 21 | 2013.05.03 | 11.30-13.00 |
| 17 | Баян-Уул | 32 | 2013.05.03 | 14.00-15.00 |
| 18 | Есөнбулаг | 83 | 2013.05.03 | 14.30-16.00 |
| | Бүгд | 376 | | |

Гэрээт цэрэгт сум тус бүр 2-оос доошгүй иргэнийг элсүүлнэ.

___оОо ___

Аймгийн Засаг даргын 2014 оны
04 дүгээр сарын 07-ны өдрийн А/237 дугаар
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

## 2014 ОНЫ 1 ДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН АЖИЛД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ, ХӨРӨНГӨ

| № | Зарцуулах зүйлийн нэр | Хүний болон материал хэрэгслийн тоо хэмжээ. /км, хоног/ | Зардал | Нийт зардал |
|---|---|---|---|---|
| 1 | Комиссын бүрэлдэхүүн хоол /өдөрт 1 удаа 3 хоног/ | 49 хүн 3 өдөр 1, 2 дугаар хоол 7000 | 49*3*7000 | 1029000 төгрөг |
| 2 | эмч цагдаа нарын ажлын хөлс/урамшуулал/ | 17 хүн 3 өдөр | 17*3*5000 | 255000 төгрөг |
| 3 | Улаанбаатар хот, Өвөрхангай, Баян хонгор аймагт цэрэг хүргэж өгөх машины шатахууны зардал | 18.5 л 2300 км – 425 л шатахуун зарцуулна. | 425л*2040 төгрөг=867000 2л масло 14000 төгрөг | 881000 төгрөг |
| 4 | Улаанбаатар хотод цэрэг хүргэж өгөх 4 хүний томилолт | томилолт | 4 хүн *10хоног* 35500 төгрөг | 1420000 төгрөг |
| 5 | Цэрэг татлагын байрны хөлс | 3 хоног | 3 хоног * 30000 төгрөг | 90000 төгрөг |
| 6 | Бүгд | 3675000 төгрөг | | |

___oOo ___

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2014 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/134 Алтай

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
дуудлага худалдаа зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2003 оны 28 дугаар "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам" тогтоол, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 206 дугаар "Аргачлал батлах тухай" тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 13 дугаар "Аймгийн газар зохион байгуулалтын 2014 оны төлөвлөгөө батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн газар зохион байгуулалтын 2014 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд 6 нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зарлан явуулах газрын хэмжээ, зориулалт, дуудлага худалдааны анхны үнийг нэгдүгээр хавсралтаар, байршлыг 2-7 дугаар хавсралтаар батлагсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны шалгаруулалтыг 2014 оны 04 дүгээр сарын 28-нд зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Алтанзагас/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZAHNR-3A-4000

02 000512

Аймгийн Засаг даргын 20.. оны .. сарын ..-ны
өдрийн ..дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зарлан явуулах газрын байршил, зориулалт, хэмжээ, дуудлага худалдааны анхны үнэ

| Д/д | Газрын байршил | Зориулалт | Хэмжээ /м2/ | Дуудлага худалдааны анхны үнэ /мянган төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Харзат баг Баянговь хүнсний дэлгүүрийн зүүн талд | Худалдаа, үйлчилгээ | 144 | 69.1 |
| 2 | Харзат баг Халдвартын шинэ эмнэлгийн зүүн талд | Худалдаа, үйлчилгээ | 288 | 138.2 |
| 3 | Харзат баг Ус-Алтай ХХК-ий урд талд | Үйлдвэр, үйлчилгээ | 600 | 144.0 |
| 4 | Баяншанд баг Шунхлай ШТС-ын урд талд | Худалдаа, үйлчилгээ | 216 | 103.7 |
| 5 | Жаргалант баг 2 дугаар цэцэрлэгийн зүүн талд | Үйлчилгээ | 216 | 103.7 |
| 6 | Баянхайрхан баг 70 жил өндөрлөгийн зүүн хойд талд | Үйлчилгээ /Зочид буудал 5 одтой/ | 600 | 288.0 |

_______________oOo_______________

Аймгийн Засаг даргын
20 14 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн
А/134 дугаар захирамжийн 2-р хавсралт

**Дуудлага худалдааны зориулалтаар**

## ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 080710 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Хэрзэт баг



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметр: 10 метр болгана)

Огноо: 2014-4-8

Хашааны координат

| Дугаар | X | Y | Урт | Цэгүүд |
|---|---|---|---|---|
| 1 | 5138007.377 | 288929.657 | 12.00 | 1-2 |
| 2 | 5138018.524 | 288925.114 | 12.00 | 2-3 |
| 3 | 5138022.967 | 288936.252 | 12.00 | 3-4 |
| 4 | 5138011.820 | 288940.704 | 12.00 | 4-1 |

Талбайн хэмжээ: 144.0 квадрат метр

Зураг үйлдсэн: . . . . . . . . М.Арвинсаланго
(Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ийн мэргэжилтэн)

[Тамга]

Хянасан: . . . . . . . . Д.Алтанзаяа
(Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ийн дарга)

Аймгийн Засаг даргын
20 14 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн
А/134 дугаар захирамжийн 3 -р хавсралт

## Дуудлага худалдааны зориулалтаар
## ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 0607 14 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Хэрмэт баг




Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Огноо: 2014-4-8

Хашааны координат:

| Дугаар | X | Y | Урт | Цэгүүд |
|---|---|---|---|---|
| 1 | 5139094.584 | 289593.889 | 12.00 | 1-2 |
| 2 | 5139104.585 | 289587.008 | 24.00 | 2-3 |
| 3 | 5139117.888 | 289606.970 | 12.00 | 3-4 |
| 4 | 5139107.907 | 289613.832 | 24.00 | 4-1 |

Талбайн хэмжээ: 288.0 квадрат метр

Зураг үйлдсэн: . . . . . . . . . . М.Арюунсолонго

(Тамга) Хянасан: . . . . . . . . . . Д.Алтанзагас

## Дуудлага худалдааны зориулалтаар
## ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Аймгийн Засаг даргын
20 14 оны 04 дугаар сарын 08 -ны өдрийн
А/134 дугаар захирамжийн 4 -р хавсралт

Нэгж талбарын дугаар: 090716 . . .
Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Огноо: 2014-4-8

Хашааны координат:

| Дугаар | X | Y | Урт | Цэгүүд |
|---|---|---|---|---|
| 1 | 5139142.718 | 289750.813 | 20.00 | 1-2 |
| 2 | 5139160.553 | 289771.822 | 30.00 | 2-3 |
| 3 | 5139174.058 | 289798.619 | 20.00 | 3-4 |
| 4 | 5139156.204 | 289807.610 | 30.00 | 4-1 |

Талбайн хэмжээ: 600.0 квадрат метр

Зураг үйлдсэн: . . . . . . М.Ариунсэлэнгэ
(Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн)

(Тамга)

Хянасан: . . . . . . Д.Алтанзагас
(Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ын дарга)

Аймгийн Засаг даргын
20.14 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн
А/139 дугаар захирамжийн 2-р хавсралт

## Дуудлага худалдааны зориулалтаар
## ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 080723 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Хөрөнт баг



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Огноо: 2014-4-8

Хашааны координат:

| Дугаар | X | Y | Урт | Цэгүүд |
|---|---|---|---|---|
| 1 | 5138104.885 | 289015.585 | 18.00 | 1-2 |
| 2 | 5138122.736 | 289013.276 | 12.00 | 2-3 |
| 3 | 5138124.274 | 289025.180 | 18.00 | 3-4 |
| 4 | 5138106.422 | 289027.486 | 12.00 | 4-1 |

Талбайн хэмжээ: 216.0 квадрат метр

Зураг үйлдсэн: . . . . . . . . . . М.Ариунсайхан
(Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн)

(Тамга)

Хянасан: . . . . . . . . . . Д.Алтанзаяа:
(Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ын дарга)